

УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

БАТЛАВ.

Ч.ЧИМЭД

**АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ЗОРИУЛСАН "ТҮРЭЭСИЙН
ОРОН СУУЦ ХӨТӨЛБӨР" ХЭРЭГЖҮҮЛЭХ /УВС-АЙМАГ/
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

2024.07.29

Дугаар: АД01/2024

Улаангом сум

1	Ажлын даалгавар боловсруулах үндэслэл	- Барилга, хот байгуулалтын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 164,А/102 дугаар тушаал -Увс аймгийн Засаг даргын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2.3.3, 3.2.1 дэх заалт -Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.6, 2.6.7, 2.6.8 дахь заалт
2	Захиалагч байгууллага	Увс аймгийн Засаг даргын Тамгын газар
3	Төсөл арга хэмжээний нэр	Ахмад настан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан "Түрээсийн орон сууц хөтөлбөр" хэрэгжүүлэх /Увс аймаг/
4	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр, санхүүжилт	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт 2024 он 1,000,000,000.0 төгрөг
5	Зориулалт	"Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр батлах тухай" Барилга, хот байгуулалтын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 164,А/102 дугаар тушаал болон Увс аймгийн Засаг даргын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Ахмад настан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан "Түрээсийн орон сууц хөтөлбөр" хэрэгжүүлэх
6	Төсөл хэрэгжүүлэх газрын байршил	Улаангом сум 5-р багт Дулааны 2-р станцын урд Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны байгууллагын зориулалтаар эзэмшиж байгаа 1300 кв 8516013612 нэгж талбарын дугаар бүхий газар /Газрын кадастрын зургийг хавсаргав/
7	Орон сууцны тоо, талбайн хэмжээ, тусгай нөхцөл	<ul style="list-style-type: none">- Орон сууцны нэг метр квадратын үнэ 2,500,000.0 төгрөг байна;- Төрийн 1,000,000,000.0 төгрөгт 43 кв хүртэлх орон сууцыг метр квадратаар тооцож тухайн ханшаар гүйцэтгэгчээс хүлээн авна;- Стандарт хэмжил зүйн хэлтсийн ажилчид дээрх үнийн хөнгөлтөд хамрагдан;

		<ul style="list-style-type: none"> - Гүйцэтгэгч шалгарч, зураг төсөл баталгаажуулан, орон сууцны ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, барилгын ажлын нийт угсралтын 20 хүртэлх хувийг гүйцэтгэсний дараагаар захиалагчтай нэмэлт гэрээ байгуулсны үндсэн дээр төрөөс олгох санхүүжилтийг бүрэн олгоно;
8	Орон сууц хүлээн авах хугацаа	2024-2025 он
9	Төслийн гүйцэтгэгчид, тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - "Түрээсийн орон сууц хөтөлбөр" нь Улаангом сум 5-р багт Дулааны 2-р станцын урд хэрэгжих; - Гүйцэтгэгч нь тусгай зөвшөөрөл бүхий барилга угсралтын ажил гүйцэтгэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байна.; - Урд нь ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагатай байх; - Төсөл хэрэгжүүлэх инженер техникийн ажилчид болон тоног төхөөрөмжтэй байх; - Нийтийн орон сууцны зураг төсөл нь Барилгын хөгжлийн төвийн магадлалаар батлагдсан иж бүрэн зураг төсөл байх; - Загвар зураг болон орон сууцны танилцуулга ирүүлэх - Зураг төслийг барилгын төвөгшлийн ангилалд хамаарах тусгай зөвшөөрөл бүхий зураг, төслийн байгууллагаар гүйцэтгүүлсэн гэрээ, тусгай зөвшөөрлийн баримт бичгүүдийг ирүүлнэ; - Барилгы угсралтын ажлын үе шатны хувиар ирүүлэх;

Хянасан:

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга

Аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн

Орон нутгийн өмчийн газрын дарга

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга

Аймгийн ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга

Боловсруулсан:

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн мэргэжилтэн

Б.Баттогтох
 Ц.Баттулга
 Р.Соёлмаа
 Г.Ууганбаяр
 Б.Батболд
 Б.Мөнхбаяр